


МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДЭЭР БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛД ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ



1. Өргөдөл, хүсэлт тавьсан албан бичиг



Өргөдөл гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө, үйл ажиллагаа эрхлэх байршлаас хамааран (СЗХ, НЗДТГ, АЗДТГ)-д хандан бүртгүүлэхийг хүссэн албан бичиг, журмын нэгдүгээр хавсралтын өргөдлийн маягтыг бүрэн нөхөж ирүүлнэ.



2. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тухай үүсгэн байгуулагчдын хурлын тэмдэглэл, шийдвэрийн эх хувь

Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, хурлаас гарсан тогтоол, шийдвэр (хэрэв нэг хувьцаа эзэмшигчтэй бол хувьцаа эзэмшигчийн шийдвэр)-ийг эх хувиар ирүүлнэ.

Тогтоол, шийдвэрт эрхлэх үйл ажиллагааны төрөл, хувьцаа эзэмшигчдийн овог нэр, хувь нийлүүлэх хөрөнгийн хэмжээ, эзлэх хувь, нэгж хувьцааны үнэ, саналын эрх зэргийг заавал тусган гарын үсэг, хуулийн этгээдийн тамгаар баталгаажуулсан байна.



3. Нэгээс илүү үүсгэн байгуулагч байгуулах нөхцөлд үүсгэн байгуулагчдын хамтран ажиллах гэрээ

Компанийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь заасан хамтран ажиллах гэрээний хувь

4. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн хувьд гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээний хувь (иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар)

5. Компанийн дүрмийн хувь

- Өмнө нь үйл ажиллагаа явуулж байсан хуулийн этгээдийн хувьд улсын бүртгэлд бүртгэгдсэн компанийн дүрмийн хуулбарыг заавал ирүүлнэ.
- Компанийн дүрмийн төсөлд үйл ажиллагааны чиглэл, хувьцаа эзэмшигчдийн овог нэр, хувь нийлүүлэх хөрөнгийн хэмжээ, эзлэх хувь, нэгж хувьцааны үнэ, саналын эрх зэргийг заавал тусган хувьцаа эзэмшигчдийн тогтоол, шийдвэрээр баталгаажуулсан байна.
- Компанийн дүрмийн төсөлд оноосон нэр болон "барьцаалан зээлдүүлэх газар" тэмдэглэгээг тусгасан байна.

6. Мөнгөн зээлийн үйл ажиллагаанд мөрдөх журам, холбогдох шийдвэр

Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны дотоод журамд барьцаа хөрөнгийн үнэлгээг тооцох аргачлал, барьцааны шаардлагыг хангах, худалдах, барьцааны эрх дуусгавар болох, мөнгөн зээлийн үйл ажиллагаатай холбоотой дотоод бүртгэл хөтлөх, түүнийг цахим мэдээллийн санд мэдээлэх болон эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцох, хэрэглэгчийг хамгаалах зэрэг зохицуулалтыг тусган хувьцаа эзэмшигчдийн тогтоол, шийдвэрээр баталгаажуулсан байна.

7. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгө, мөнгөн хөрөнгөд оруулах мөнгөн хөрөнгийн орлогыг тодорхойлох баримт бичиг, мөнгөн хөрөнгийн гарал үүслийн тодорхойлолт

- А. Өмнө нь үйл ажиллагаа явуулж байсан компанийн хувьд тухайн жилүүдийн аудитлагдсан эсхүл санхүүгийн тайлан, татварын тайлан, санхүүгийн тайлангийн хуулбар гэх мэт.
- Б. Шинээр үйл ажиллагаа эхлэх компанийн хувьд эхлэлтийн тайлан, тухайн хөрөнгийг олсон олж авсан үйл ажиллагааг нотлох баримт.
- В. Иргэн бол тухайн хөрөнгийг олсон олж авсан үйл ажиллагааг нотлох баримт болон нийгмийн даатгал, татварын тодорхойлолт, татвар төлсөн баримт, холбогдох гэрээ хэлцэл гэх мэт.

8. Хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг санхүүгийн байгууллага дахь тухайн хуулийн этгээд (иргэн бол өөрийн)-ийн дансанд байршуулсан банкны тодорхойлолт, дансны хуулга


Бүртгэх байгууллага өргөдлийг хянаж, шийдвэрлэх хүртэлх хугацаанд өргөдөл гаргагч нь байршуулбал зохих мөнгөн хөрөнгийн хэмжээг бууруулж, зарлагын гүйлгээ хийхгүй.

9. Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага нь дор дурдсан баримт бичгийг бүрдүүлж ирүүлнэ.



1. Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага, менежер, ажилтан нь журмын 6-р хавсралтаар баталсан **эрх бүхий албан тушаалтан болон бусад боловсон хүчний тодорхойлолтыг** бүрэн, үнэн зөв нөхөж ирүүлнэ.

2. Мэргэжлийн дипломын хуулбар



3. Мөнгөн зээлийн үйл ажиллагааны журмын талаарх гүйцэтгэх удирдлага, менежерийн сургалтад хамрагдсаныг нотлох **сертификатын** хувь эсхүл сургалт явуулсан эрх бүхий байгууллагын тодорхойлолт

4. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 5.1.10-т заасан гэмт хэрэгт хариуцлага хүлээж байсан эсэх талаарх эрх бүхий байгууллагын тодорхойлолт



А. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй эсэх цагдаагийн тодорхойлолт

Б. Шүүхийн шийдвэрээр бусдад төлбөргүй эсэх тодорхойлолт



5. Эрх бүхий албан тушаалтан, холбогдох этгээд нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдэд тавигдах шалгуурыг хангасныг нотлох баримт.

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 179 дүгээр тогтоолоор баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ын гуравдугаар хавсралтад заасан баримт бичиг, асуулгын хуудсуудыг бүрэн бөглөж ирүүлэх.

6. Гүйцэтгэх удирдлага, ажилтантай байгуулсан эрх бүхий этгээдийн томилсон **шийдвэрийн хувь, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт;**



Байнга, ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэн нь энэ хэсгийн 1-5-д заасан шаардлагыг хангасан байна.

10. Үйл ажиллагаа явуулах ажлын байр нь холбогдох шаардлага хангасныг нотлох баримт бичиг, тоног төхөөрөмж, программ хангамж, эд зүйлсийг гэрэл зургаар баталгаажуулах.


Ажлын байрны цахилгаан болон галын аюулгүй байдлын шаардлага хангасныг нотлох эрх бүхий байгууллагын дүгнэлт (олон байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг ажлын байрны хувьд түрээслүүлэгч байгууллагын тухайн барилгад гаргуулсан дүгнэлтийн хуулбар).

Үйл ажиллагаа явуулах ажлын байр нь өөрийн өмчлөл, эзэмшлийн байр бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар (түрээсийн байр бол түрээсийн гэрээний хуулбар).



Бизнес төлөвлөгөө (3 жилээр), эхлэлтийн тайлан тэнцэл (Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 81 дүгээр тогтоолын 7-р хавсралт)

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хуулийн дагуу хяналт тавих ажилтныг томилсон шийдвэр, журам



Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.11